

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН
УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН 2023 ОНЫ ЭХНИЙ 07 САРЫН БАЙДЛААРХ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2023-08-17.

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
Зорилт 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.				
1	2.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлж, хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.	Улсын төсөв 1,5 сая	Аймгийн хэмжээнд 7 сарын байдлаар 32588 халдварт бус өвчлөл бүртгэгдэж, нийт нас баралт 129 тохиолдол бүртгэгдсэн байна. Осол гэмтлийн шалтгаант өвчлөл 446, хорт хавдрын өвчлөл 36 тохиолдол тус тус бүртгэгдсэн, нь нийт халдварт бус өвчлөлийн 1,5 хувийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 15 тохиолдол, хавдарын шалтгаант нас баралтын 15 тохиолдол тус тус бүртгэгдсэн нь нийт нас баралтын 23,2 хувийг эзэлж байна. Аймгийн Хөдөлмөр магадлан хэлэлцэх комиссоор шинээр 90 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтооход осол гэмтлийн шалтгаант хөдөлмөрийн чадвар алдалт 21,1 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоног бүрийн 2 дахь өдрийг энэ чиглэлээр сургалт мэдээлэл хийдэг болгосноор нийт 2578 иргэнд хийгдсэн байна.	100
2	2.2.2. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.	Улсын төсөв 151,3 сая	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 373 дугаар тушаалын дагуу томуу, томуу төст өвчин, коронавирусын халдварын тандалтын тогтолцоог нэгтгэн аймгийн хэмжээнд 2022-2023 оны томуугийн улиралд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, тандалтын мэдээг 7 хоног тутамд нийт эрүүл мэндийн байгууллагуудаас татан авч, дүгнэлт хийн хариу арга хэмжээг авлаа. 2023 оны 32 дугаар 7 хоногийн мэдээгээр аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчлөл амбулаторийн үзлэгт 4%, дуудлагын үзлэгт 5.7%-тай, аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчлөлийн тархалтын түвшин “Улирал хоорондын түвшин”-д байна. Коронавируст халдварын батлагдсан шинэ тохиолдол 121 өссөн дүнгээрээ 15918 байна. Өнөөдрийн байдлаар гэрээр эмчлэгдэж байгаа иргэн байхгүй байна. Коронавируст халдварын тархалт “Ногоон” буюу тархалт бага/тогтвортой” түвшинд байна. Заавал хийх товлолт дархлаажуулалтад хамрагдвал зохих нийт 2255 хүүхдээс хамрагдсан 2077 хүүхдийг хамрууллаа. Хамралт 92,1%-тай байна.	100

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
			Аймгийн хэмжээнд 361 халдварт өвчин бүртгэгдэж 10 000 хүн амд 76,2 промилль болж өнгөрсөн оны мөн үеэс 2622 тохиолдол буюу 10 000 хүн амд 550,9 промилиор буурсан байна.	
3	2.2.3. Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны загвар төвийг нийслэл хотод байгуулна.	-	Хамраалгүй	-
4	2.2.4. Аймаг, дүүргийн түвшинд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна.	Улсын төсөв 1,0 сая	Одоогийн байдлаар Эрүүл мэндийн газарт Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс гэсэн зохион байгуулалтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулахаар бүтцийн төсөл загварыг гаргалаа.	70
5	2.2.5. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.	Улсын төсөв 2,5 сая Глобал сан 6,0 сая	Явуулын тусламж үйлчилгээг алсдагдсан сумдын багийг иргэдийг хамруулах хүрээнд Аймгийн Засаг даргын санаачилгаар аймгийн хэмжээний нийт 14 суманд нарийн мэргэжлийн 6 эмчийн үзлэг шинжилгээ оношилгоог зохион байгууллаа. Үзлэг оношилгоо, шинжилгээг нийт 3526 иргэнийг хамруулсан байна. Үзлэгээр хоол боловсруулах замын эмгэг 51 хувь, цагаан судлалын өвчин буюу нуруу нугасны шохойжилт 41 хувьтай зонхилж байна. Элэгний хавдар 2, элэгний үүсгэвэр 2, элэгний хатуурал 3, элэгний өөхжилд 19, уушгины өөрчлөлттэй 14 бусад өвчлөл 789 илэрсэн байна. Өвчлөл илэрсэн иргэдийг 2 дахь болон 3 дахь шатлалын эмнэлэгт илгээж, эрүүлжилт 25,0 хувьтай байна. Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг эрчимжүүлэх хүрээнд аймгийн төвийн нийт 570 хүүхэд үзлэгт хамруулж 373 өвчлөл илрүүлэн 68.9 хувийг эрүүлжүүлсэн байна. Аймгийн хэмжээнд 101351 үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 23,1 хувь, амбулаторийн үзлэг 63,8 хувь, идэвхтэй хяналт 7,4 хувьтай байна. Нийт иргэдийн 11,5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалын дагуу “Хүн амын нас, хүй, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг”-т 0-17 насны хүүхдийн үзлэгт нийт хамрагдвал зохих хүүхдийн 67.2%, 18 дээш насны иргэдийн 20.1% тус тус хамруулаад байна.	100
6	2.2.6. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ.	ЭМДС	18 албан байгууллага аж ахуйн нэгжийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар гэрээ хийсэн. Гэрээний дагуу 8 байгууллагын 136 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд ажиллаж буй төрийн	100

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
			болон аж ахуйн нэгжийн нийт албан хаагч нарын 93,5 хувь нь Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.	
7	2.2.8. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.	Улсын төсөв 1,3 сая	2023 оныг “Амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” жил болгон зарлаж эмнэлэг бүр нээлттэй мэдээллийн өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт төрийн болон төрийн бус 14 байгууллагын болон иргэдийн төлөөлөл бүхий 853 иргэн оролцож, сургалтын материал тараалаа. Аймгийн төвд тус нээлтийн үйл ажиллагааг аймгийн ЗДТГ, Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран “Эрчүүдээ хайрлая” уриалгын дор зохион байгуулж, тус өдөрлөгөөр эрүүл амьдрах амьдралын 12 зөв дадал хэвшил болон эрчүүдэд зонхилон тохиолдож буй өвчлөл, түүнээс урьдчилан сэргийлэлт сэдвүүдээр мэдээллүүдийг өгч байгууллага, аж ахуйн нэгжийн эрэгтэй ажилчид болон багийн иргэд эрэгтэйчүүд нийт 203 хүнийг хамрууллаа. Өдөрлөгт хамрагдсан нийт хүний тоо 1053 байна. Давхардсан тоогоор нийт 68621 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгосон байна. Иргэдийн оролцооны хувь 100 хувьтай	100
8	2.2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	Улсын төсөв 10,3 сая	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 373 дугаар тушаалын дагуу томуу, томуу төст өвчин, коронавирусын халдварын тандалтын тогтолцоог нэгтгэн аймгийн хэмжээнд 2022-2023 оны томуугийн улиралд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, тандалтын мэдээг 7 хоног тутамд нийт эрүүл мэндийн байгууллагуудаас татан авч, дүгнэлт хийн хариу арга хэмжээг авлаа. Коронавируст халдварын батлагдсан шинэ тохиолдол 121 өссөн дүнгээрээ 15918 байна. Өнөөдрийн байдлаар гэрээр эмчлэгдэж байгаа иргэн байхгүй байна. Коронавируст халдварын тархалт “Ногоон” буюу тархалт бага/тогтвортой” түвшинд байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 85,8, гамшгийн үеийн хүний нөөцийн хангалт 91,0 хувьтай байна.	100

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
9	2.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.	-	Тус аймагт нь 47199 хүн амд 704 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Нийт хүн амаас эрэгтэй 23717, эмэгтэй 23482 байна. Төрөх насны 11218 эмэгтэй, 1 хүртэлх насны 933, 1-5 насны 5350, 6-17 насны 10388 байна. Аймгийн хэмжээнд их эмч 141, сувилагч 139 ажиллаж байгаа бөгөөд 351 ор эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглаж байна. Нийт 101351 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 22711 буюу 22,4 хувьтай байна. Эмнэлэгт шинээр 6284 иргэн хэвтэж, 6234 иргэн эмнэлгээс гарч, 46031 ор хоног ашиглаж 7,4 дундаж ор хоног эзэлж байна.	100
10	2.2.12. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ.	Хандив тусламж 87.5 сая	Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн нийт 67 эрүүл мэндийн байгууллага ажилласнаас ортой эмнэлэг 2, лаборатори 2, ариутгал халдваргүйтгэл 4, үүдэн эмнэлэг 20, бусад нь эмийн болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. 2 ортой хувийн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Хувийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг сайжруулах эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг олшруулах чиглэлд анхаарч ажилласан бөгөөд 2 эмнэлэгт зээл авахад дэмжлэг үзүүлснээр хэт авианы оношилгооны аппарат болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангагдсан байна. Эмнэлгүүдийн орны ачааллыг хуваалцах зорилгоор 2 ортой хувийн эмнэлэгт 426 иргэнд үзлэг хийж, 423 иргэнийг хэвтүүлэн эмчилж 8,9 ор хоног эзэлж байна. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр аймгийн төвийн 2 эмийн санд олголоо.	100
11	2.2.14. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.	Улсын төсөв 3,5 сая	Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг таниулан иргэдэд зөв дадал хэвшил төлөвшүүлэх зорилгоор “Энэ жилдээ-Эрүүл жиндээ”, “Цаг гаргая”, “Осол гэмтлээс сэргийлье”, “Архи таныг уусаар л байна...”, “Тамхи таныг татсаар л байна...”, “Хавдраас сэргийлж эко саваа хэрэглэе”, “Сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалъя”, “Эхийн сүү-Дархлаа” зэрэг аян арга хэмжээг бусад салбар, байгууллага хамт олны оролцоотой зохион байгуулж давхардсан тоогоор 16000 хүнд мэдээлэл сургалт, сурталчилгаа хийсэн байна. Мөн ажиллагсдын болон өөрийн эрүүл мэндээ хамгаалах, ажлын байр, гэр бүлийн хүрээнд эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэх, бий болгох зорилгоор байгууллага, хамт олон, гэр бүл, иргэдийн дунд “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл	100

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
			<p>мэндээ дээдлэгч өрх, гэр бүл, иргэн"-ийг шалгаруулах болзол журмыг танилцуулан 15 байгууллагад зөвлөгөө зөвлөмж өгсөн.</p> <p>Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт эхний 7 сарын байдлаар артерийн гипертензийн үзлэгт 51,7 , чихрийн шижин хэв шинж-2-ийн үзлэгт 47,4, хөхний эрт илрүүлэг үзлэгт 27,8, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлэг үзлэгт 44,1 хувь тус тус хамрагдаж хамрагдалт 42,8 хувьтай байна. Шинээр артерийн гипертензээр 28, чихрийн шинжин хэв шинж-2- 6 тус тус оношлогдож эмчийн хяналтад авч эмчилж эрүүлжүүлж байна.</p>	
12	<p>2.2.16. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.</p>	<p>Улсын төсөв 4,6 сая</p>	<p>Эхний 7 сарын байдлаар 409 эх төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 31 төрөлтөөр нэмэгдсэн байна.</p> <p>Амьгүй төрөлт бүртгэгдээгүй. Эхийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэл бүртгэгдээгүй. Жирэмсний хяналтад 397 жирэмсэн эмэгтэй байгаа бөгөөд шинээр хяналтад 390 эмэгтэй орсноос жирэмсний эрт үеийн хяналт 90.8 хувьтай байна.Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 6 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 14.6 промилль байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.6 промилиэр өссөн үзүүлэлттэй байна. Перинаталь эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 2.4 промилль байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.1 промилиэр буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Жирэмсний хяналтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд:</p> <p>Сумдын эх барихуйн тусламж, үйлчилгээ хариуцсан их эмч, эх баригч нарыг хуваарийн дагуу ажлын байрны 5 хоногийн сургалтад 17 эмч, эх баригч нарыг хамрууллаа. Сургалтыг Нэгдсэн эмнэлгийн Эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх газар I,II хэсэг, төрөх тасагт зохион байгуулж, сургалтыг онол болон дадлага гэсэн хэлбэрээр явуулж, оролцогч нарын мэдлэгийг дээшлүүлж, ур чадварыг сайжрууллаа. Сургалтаар жирэмсний хяналтын товллын үзлэгийн чанарыг сайжруулах, эх барихын яаралтай тусламж, гэр бүл төлөвлөлт, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж гэсэн чиглэлээр мэдээлэл өгч, үр дүнг гардан үйлдлээр тооцож ажиллалаа.</p> <p>Луус, Хулд, Өлзийт, Дэлгэрцогт, Сайнцагаан сумдын эх барихын тусламж, үйлчилгээнд Дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зааварчилгаа өгч, зөвлөмж өгч ажиллалаа.</p> <p>Гурвансайхан, Луус, Хулд, Өлзийт, Дэлгэрцогт, Сайнцагаан сумдын эрүүл мэндийн төвд хянагдаж байгаа жирэмсэн эмэгтэйн хяналтын 26 хөтөчид үнэлгээ хийж дүгнэхэд, чанарын хэрэгжилт 81.6 хувьтай байна.</p>	100

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
			<p>Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр:</p> <p>0-5 хүртэлх насны 4432 хүүхэд гэрийн эргэлтэд хамрагдахаас 2661 буюу 60,0 хувь нь гэрийн эргэлтэд хамрагдаж, 549 хүүхдийг эрүүлжүүлсэн байна. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдээр 18 ба 36 сартай 377 хүүхэд эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдаж, үзлэгийн хувь 63,1 байна. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 52 хүүхэд өвчлөлтэй гарснаас 100% эрүүлжүүлсэн байна.</p> <p>Хоол тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сар бүр 0-5 насны 4125 хүүхдээс 1373 хүүхдийн жинлэсэн байна. Туршаалтай туранхай өсөлтийн хоцрогдолтой хүүхэд бүртгэгдээгүй байна.</p>	
13	2.2.18. Иргэд эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 хоног бүрийн 2 дахь өдрийг энэ чиглэлээр сургалт мэдээлэл хийдэг болгосноор нийт 2578 иргэн хамрагдлаа. 2023 оны эхний 7 сарын байдлаар хөдөлмөр магадлах комиссоор шинээр 90 хүн орсноос осол гэмтлийн шалтгаантай 21,1 хувь, нүдний шалтгаантай 8,9 хувь, Чих хамар хоолойн шалтгаантай 8,9 хувь, мэс заслын шалтгаантай 20,0 хувь нь орсон байна. Сунгуулсан 424, цуцалсан 58 хүн байна.	100
14	2.2.19. Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгана.	ЭМДС	<p>Эрүүл мэндийн даатгал төлөгч малчин 2895, хувиараа хөдөлмөр эрхлэгч 906, оюутан 102, нийт 3903 иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бөгөөд нийт эрүүл мэндийн даатгалд 84,9 хувь хамрагдсан байна.</p> <p>Орлого бүрдүүлэлт ах ахуйн нэгж байгууллага гүйцэтгэл 1,480, 552, 500 буюу 96,5 хувь, шимтгэл өөрөө төлдөг даатгуулагч гүйцэтгэл 230,890,200 буюу 82,8 хувь байна.</p>	88,0
15	2.2.20. Төрийн өмчийн эмнэлгийн санхүүжилтийн болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	-	Аймгийн Нэгдсэн эмнэлгийг удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэхээр аймгийн Засаг даргаар сонгон шалгаруулах захирамж гаргуулснаар Төрийн бус байгууллагын төлөөлөл болох 3 гишүүнийг сонгон шалгаруулан сонгосон. Бусад 6 гишүүнийг сонгох үйл ажиллагаа хийгдэж байна.	40
16	2.2.22. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ.	Гүйцэтгэлийн санхүүжилт 3,382 сая	Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд 2021 оны 3 сараас эхлэн шилжиж, 14 нэр төрлөөр эмчилгээ үйлчилгээг үзүүлж байна. Эхний 7 сарын байдлаар аймгийн нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлийн санхүүжилтийг 86,6 хувьтай авч, 9,5 хувийн хасагдалтай байна. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд 2022 оноос эхлэн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжиж өрхийн эрүүл мэндийн төв 4, сумын эрүүл мэндийн төв 8 төрлийн тусламж	87,8

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
			үйлчилгээ үзүүлж байна. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн гүйцэтгэл 89.1 хувьтай байна.	
17	2.2.23. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгоно.	-	Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх, иргэдэд уламжлалт анагаах ухааныг сурталчлах зорилгоор 7 сэдвийн хүрээнд 484 иргэнд эрүүл мэндийн сургалт хийсэн байна. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг аймгийн төвд ажиллаж байгаа бөгөөд тус эмнэлгээр 1679 иргэн амбулаториор үзүүлж, 733 иргэн хэвтэн эмчлүүлж 5864 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 8,0 байна. Өвөр монголын өөртөө засах орны Баяннуур аймагт албан ёсны айлчлал хийж эмч нарын үзлэгийг зохион байгуулах тухай санал солилцсон. Гадаад харилцааны яамаар дамжуулан гэрээ хийхээр төлөвлөж 9,10 дугаар сард үзлэг шинжилгээ оношилгоо хийлгэх ажлыг эхлүүлэхээр болсон.	70
18	2.2.25. Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг (телемедицин) өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд ашиглаж хэвшинэ. Алслагдсан сумын эрүүл мэндийн төвөөс холбогдож үйлчлүүлэгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.	-	Мэс засал, эмийн чанар аюулгүй байдал, олон улсын эмнэл зүйн программ хэрхэн ашиглах, хүүхэд болон насанд хүрэгчдийн томуугийн эмчилгээ зэрэг нийт 8 удаагийн зөвлөгөө мэдээлэл хүргэлээ Төрөлжсөн нарийн мэргэжлийн төвөөс зөвлөгөө 8 удаа, сумдад нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөөг 14 удаа тус тус авч нийт 30 удаа зөвлөгөө авсан.	100
19	2.2.26. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.	-	Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн цахим, UPTODATE платформ, тусгай зөвшөөрлийг цахим, Зүрх судасны нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (МонПЕН) төслийн хүрээнд Зүрх судасны MNCARDIO программ хангамж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн E-hospital, Ehealth программ, статистик бүртгэл мэдээллийн hinfo программ, халдварт өвчнийг эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах Ewar программ, эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн цахим программ, эрүүл мэндийн ажилтын нэгдсэн бүртгэлийн сан программыг тус тус нэвтрүүлэн хэрэгжүүлж нийт 11 программыг 95 хувь ашиглаж байна. E-Mongolia аппликэйшн болон ТҮЦ машинаас эмнэлгийн цахим магадалгаа, вакцинжуулалтын цахим гэрчилгээ авч байна. Өрх, сумын эрүүл мэндийн төв 13а маягтаар лавлагаа шатлалын эмнэлэгт цахимаар илгээж эхлээд байна.	100
20	2.2.27. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт,	ОНХС 1 тэрбум 303,0 сая	Аймгийн 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгыг 2023 оны 7 сарын 26 нд Улсын комисс урьдчилан дүгнэлт гаргаж зөвлөмж өгсөн. Дээрх зөвлөмжийн дагуу ажил хийгдэж байна. Гүйцэтгэл 98.0 хувьтай	100

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
	чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	Улсын төсөв 1,5 тэрбум	байна. Өлзийт-Мандал өрхийн эрүүл мэндийн төв Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өргөтгөл хийхээр 1 тэрбум 030 сая төгрөгийн суулгаж 2023 оны 7 сарын гүйцэтгэл 50.0 хувьтай. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Адаацаг сумын эрүүл мэндийн төв нь урсгал засварт 300 сая төгрөгөөр засах ажил эхэлсэн байна. Ингэснээр орчин үеийн стандартад нийцсэн эмнэлэг 10 болсон байна.	
21	2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.	ДЭМБ-ын санхүүжилт 16,0 сая Хандив тусламж 136,4 сая Улсын төсөв 14,5 сая	Япон Улсын Засгийн газраас “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 128,5 сая төгрөгийн 14 ширхэг спидометрийг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хуваарлан өглөө. Өндөршил, Хулд сумын эрүүл мэндийн төвүүд хог хаягдал ангилан ялгах путик, ор, өвчтөний хоолны шкафыг улсын төсөв бүхий 14,5 сая төгрөгөөр худалдан авсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн буцалтгүй тусламж 3,9 сая төгрөгийн 35 ширхэг пульсоксиметрийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд хуваарлан өглөө. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газарт Шуурхай удирдлагын нэгж байгуулах 16,0 сая тоног төхөөрөмжөөр хүлээлгэн өглөө. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 8 нэр төрлийн 166,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувьтай байна.	100
22	2.2.29. Хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэж, орон нутгийн хэрэгцээг хангаж, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгана.	Улсын төсөв 29,7 сая	Лавлагаа шатлалд чих хамар хоолой, ариутгал, халдварт, компьютер томограф/рентген туяа судлал, 3 сумын эрүүл мэндийн төвд бүртгэл мэдээлэл, Сайнцагаанд сэргээн засах судлал, Зоонозын өвчин судлалын төв, Баянжаргалан сумын эрүүл мэндийн төвд дархлаажуулалтын сувилагч нийт 10 сувилагч, тусгай мэргэжилтэн мэргэшүүлэн бэлтгэлээ. Ингэснээр мэргэшүүлсэн эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо 31 боллоо. Лавлагаа шатлалын эмнэлэгт 7 чиглэлээр их эмчийг мэргэшүүлэн бэлтгэлээ. Дэлгэрхангай, Өндөршил сумын эрүүл мэндийн төвийн их эмчийг хэвлийн хөндийн хэт авиа оношилгооны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулснаар нарийн мэргэжлийн эмчийн хангалтын 96,0 хувьтай байна.	100

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
			Анагаахын сургуулиудтай хамтран ажиллаж, 4 шинээр төгсөн ирж сувилагчийн хангалт 87,0 хувьтай байна. Ингэснээр хүний нөөцийн хангалт 91,0%-тай байна Эрүүл мэндийн салбарт нийт 692 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд гэрт 271 буюу 39,2%, орон сууцанд 295 буюу 42.6%, бусад нөхцөлд 18,2% нь амьдарч байна. Цагаандэлгэр сумын эрүүл мэндийн төв 1 их эмч, 1 сувилагчийг албаны орон сууцаар, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 1 их эмч, 1 бага эмч, Нэгдсэн эмнэлгийн 3 их эмч, 2 сувилагч, тусгай мэргэжилтэнд байгууллага нь орон сууцны 6%-ийн дэмжлэг үзүүлэхэд хамтран ажилласан. Ингэснээр орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь 42,6-тай байна.	
23	2.2.34. Эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэж мэдлэг, чадвар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах, сургах арга зүйг тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлнэ.	Улсын төсөв 0,150,0	Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын 27 багшид амьдралын зөв дадал хэвшил болон эмийн зохистой хэрэглээний талаар сургалтыг зохион байгуулсан. Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооноос зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бэлгийн цогц боловсролыг хүртээмжтэй хүргэх чадавх олгох” сургагч багш бэлтгэх сургалтад Эмнэлгийн тусламжийн хэлтсийн эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн хамрагдан, сургагч багшийн гарын авлагаар хангагдсан. Сургалт явуулах бэлтгэл ажлын хүрээнд оролцогчдын судалгааг гаргаж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж байна.	40
24	2.2.35. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна.	Улсын төсөв 0,500,0	Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг хийх төлөвлөлтийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3-4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн. Судалгааны асуумжийг боловсруулах шатандаа байна. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх зорилгоор эмч нарын өдөр, олон улсын сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн өдрийг тохиолдуулан нийт 7 илтгэл хэлэлцүүлээ.	40
25	2.2.37. Иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.	ЭМДС	Урт хугацааны тусламж үйлчилгээ болох сэргээн засахаар нийт 861 хүн 51,420,000 төгрөг, хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд 246 хүн 69,800,000 төгрөг санхүүжилт авч ажилласан байна. Сувилахуйн тусламж үйлчилгээгээр санхүүжилт аваагүй байна.	70

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Зарцуулсан төсөв (эх үүсвэр)	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5
26	2.2.38. Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээг хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлж аливаа өвчин эмгэгийг эрт илрүүлж, эмчлэх боломжийг бүрдүүлнэ.	Улсын төсөв 1 тэрбум 505,6 сая	Өвчлөлийг эрт илрүүлэх, эмчлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд шинээр Компьютертомографийг улсын төсвийн 1 тэрбум 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар авч суурилуулан нэн шаардлагатай 20 хүнд шинжилгээ оношилгоо хийж, тархины хагалгааг 2 хүнд хийснээр 3 дахь шатлалын эмнэлэгт үзүүлж буй урсгалыг бууруулж байна. Компьютертомографийн эмч, рентген техникчийг төрийн санхүүжилтээр 3 сарын хугацаагаар бэлтгэн ажиллууллаа.	100
27	2.2.39. Алслагдмал сум, орон нутаг, хот, нийслэлд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар ижил түвшинд очиж, цахим эрүүл мэндийн системд бүрэн шилжинэ.	-	Нэгдсэн эмнэлэгт E-Health , анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд E-HOSPITAL эмнэл зүйн программ хангамжийн өдөр тутам үйл ажиллагаандаа ашиглаж мэдээлэл солилцооны нэгдсэн платформ (HIEP) холбон мэдээлэл солилцох үйл ажиллагаа тогтмолжсон.	100
Зорилт 2.7. Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.				
28	2.7.2. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ.	Улсын төсөв 1,8 сая	Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сангийн санхүүжилтээр, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэмжлэгтэйгээр “Хүүхдийн өвчний цогц менежмент” эмнэл зүйн сургалтыг зохион байгуулж, 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж чадавхжууллаа. Давхардсан тоогоор 6293 удаагийн жирэмсний ЭХО хийгдсэн байна. Ургийн гажиг илрүүлэх жирэмсний 13,20,32 долоо хоногтойд 344 эхийг хамруулснаар ургийн гажиг 6 тохиолдол илэрч амьдрах боломжтой 2 төрж, 3 тохиолдолд жирэмснийг тасалж, 1 тохиолдол хяналтад байна.	70
29	2.7.4. Ургийн үеэс эхлэн монгол хүний насны онцлогт тохирсон эрүүл мэнд-бие бялдар, боловсрол, эх оронч хүмүүжил олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	-	Хөтөлбөр боловсуурлагдаагүй	-
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ				88,1

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР